



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 08 сарын 22 өдөр

Дугаар А/63

Улаанбаатар хот

Эмч нарын шуурхай зөвөлгөөнийг
явуулах тухай.

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн удирдлагын зөвлөлийн хурлын 2017 оны 07 сарын 06-ний өдрийн 02 тоот шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1.Эмч нарын шуурхай зөвөлгөөнийг хөтлөх журмыг нэгдүгээр, эмч нарын шуурхайн хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Шуурхай зөвөлгөөнийг хөтлөх журам, зөвөлгөөний хуваарийг 2017 оны 07 сарын 25-ны өдрөөс мөрдөж, төвийн хурлын танхимд зохион байгуулсугай.

3. Эмч нарын шуурхай зөвөлгөөн нь цаг үеийн шаардлагаар өөрчлөгдсөн тохиолдолд төвөөс урьдчилан тасгийн дарга эрхлэгч нараар мэдээллэх бөгөөд хүндэтгэх шалтгааны улмаас шуурхай зөвөлгөөнд оролцох боломжгүй тохиолдолд уг шалтгааныг хүний нөөцийн менежер /Ц.Энхбаясгалан/-д урьдчилан мэдэгдэж байхыг НЭМТҮ-ний, поликлиникийн, салбар амбулаторийн, хэвтэн эмчлүүлэхийн тасагуудын нийт эмч нар болон Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Эмч нарын шуурхай зөвөлгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлт болон өнгөрсөн 14 хоногийн эмчилгээ үйлчилгээний талаарх мэдээллийг чанартай гарган шуурхай болох долоо хоногийн өмнөх өдөр буюу даваа гаригийн 12:00 цаг хүртэл мейлээр төсөл хөтөлбөр, гадаад харилцаа, нийгмийн асуудал хариуцсан /О.Ууганбаяр/-т өгөхийг поликлиникийн эрхлэгч /Д.Молор-Эрдэнэ/, салбар амбулаторийн эрхлэгч /Г.Оюунцэцэг/, хэвтэн эмчлүүлэх тасгийн эрхлэгч /Д.Соёл-Эрдэнэ/, НЭМТҮХ тасгийн өрхийн менежер /Г.Үүрийнтуяа/, сувилахуйн албаны дарга /Б.Халиунгэрэл/, аж ахуйн дарга /П.Буяндаваа/, Өрхийн ЭМТ-ийн салбар зөвлөлийн дарга нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг хүний нөөцийн менежер /Ц.Энхбаясгалан/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БОДЬЦЭЦЭГ

Нийслэлийн Хан-Уул Эрүүл мэндийн төвийн
даргын 2017 оны 08 сарын 21-ний өдрийн
4/63 дугаар тушаалын хавсралт.01



ЭМЧ НАРЫН ШУУРХАЙ ЗӨВӨЛГӨӨНИЙ ЖУРАМ

Нэг. Зорилго

Тус Эрүүл мэндийн төвийн эмч нарын хариуцсан ажлын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, өгсөн үүрэг даалгаврын биелэлт, үр дүнг тооцох, мэдээ мэдээллийг сайжруулах гүйцэтгэлд хяналт тавих

Хоёр. Зорилт

2.1. Эмч нарын шуурхай зөвлөгөөнийг батлагдсан хөтөлбөр, удирдамжийн дагуу хуваарьт өдрүүдэд чанартай зохион байгуулна.

2.2. Шуурхайгаар өгсөн үүрэг даалгаврын гүйцэтгэлийг үнэлнэ.

2.3. Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, НЭМТҮХ орлогч дарга, Поликлиникийн эрхлэгч, салбар амбулаторийн эрхлэгч, аж ахуйн дарга, захиргааны албадуудын дарга /ЭМТҮЧанарын алба, хүний нөөцийн алба, сувилахуйн алба, санхүү, мэдээлэл-статистик/ болон Өрхийн ЭМТ-ийн дарга нарын гэрээг дүгнэхэд шалгуур үзүүлэлт болгон дүгнэнэ.

Гурав. Шуурхай зөвлөгөөнийг хөтлөн явуулах зарчим

3.1. Шуурхай зөвлөгөөний бэлтгэл ажлыг ханган, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангах ажлыг чанаржуулж, сайжруулахад чиглэгдсэн байх.

3.2. Ажлын төлөвлөлт, хувиарлалт, жигд оролцоонд тулгуурласан байх.

3.3. Үүрэг даалгаварын гүйцэтгэлийг үнэлэх, эргэн мэдээлэл, хариуцлага тооцох

Дөрөв. Шуурхай зөвлөгөөнд бэлтгэх

4.1. Эмч нарын шуурхай зөвлөгөөнийг хөтлөн явуулахын өмнөх өдөр шуурхай зөвлөгөөнөөр хэлэлцэх асуудал, цаг үеийн холбогдолтой мэдээллүүдийг компьютерт файл, фолдер үүсгэн бэлтгэнэ.

4.2. Тасаг нэгжүүд шуурхай зөвлөгөөнөөр танилцуулах асуудал, цаг үеийн холбогдолтой мэдээллүүдийг мэдээлэл хийх хүн нь урьдчилан бэлтгэж Power Point хийж урьдчилан хэвлэн хүний нөөцийн менежерт хүргүүлнэ.

4.3. Шуурхай зохион байгуулах өрөө, тасалгаа, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулна.

4.4. Шуурхай зөвлөгөөнд оролцогчдын ирцийн бүртгэлийг нягт нямбай хөтөлнө.

4.5. Өмнөх шуурхайгаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хүний нөөцийн менежерт бичгээр хэвлэж өгнө.

Тав. Шуурхай зөвөлгөөн хийх.

5.1. Шуурхай зөвөлгөөнийг Эрүүл мэндийн төвийн дарга удирдана.

5.2. Даргын эзгүйд орлогч дарга удирдана.

5.3. Шуурхай зөвөлгөөнийг батлагдсан хуваарийн дагуу сард 2 удаа Мягмар гариг бүр 15:30 цагт Эрүүл мэндийн төвийн хурлын зааланд болно. Зөвөлгөөний хугацаа цаг өөрчлөгдвөл жич зарлана.

5.4. Эрүүл мэндийн төвийн нийт эмч нар болон Өрхийн Эрүүл мэндийн төвийн дарга нар зөвөлгөөнд оролцоно.

Зургаа. Шуурхай зөвөлгөөний дараалал

6.1. Шуурхайд өмнөх шуурхайгаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт болон 14 хоногт хийсэн ажлаа тасаг, нэгж, албад болон өрхийн ЭМТ-ийн салбар зөвлөлийн хуваарийн дагуу 7 минутанд багтааж тус тусдаа танилцуулах.

6.2. Шуурхайд орчин үеийн эмчилгээ үйлчилгээний талаар мэдээлэлийг тасаг нэгжээс ээлжлэн хуваарийн дагуу нэг эмч шуурхай бүрд хийх, мэдээлэлтэй холбоотой асуулт хариулт, санал хэлэх 3-5 минут

6.3. Хурал даргалагч шуурхай зөвөлгөөнийг дүгнэж, дараагийн 14 хоногт хийж гүйцэтгэх болон цагийн холбогдолтой ажлын талаар үүрэг даалгавар өгөх.

Долоо. Шуурхай зөвөлгөөн хөтлөн явуулах ажилтны хүлээх үүрэг

7.1. Шуурхай зөвөлгөөний хурлын тэмдэглэлийг стандартад заасны дагуу нууцын ажилтан хөтлөнө.

7.2. Шуурхай зөвөлгөөнөөр эмч нарт өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаатай хурлаас гарсан шийдвэрийг тодорхой тэмдэглэнэ.

7.3. Шуурхайгаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, цаг үеийн талаар мэдээлэл хийсэн хүнээс нь материалыг нь нэхэн авч хурлын тэмдэглэлийн хамт нууцын ажилтан архив бичиг хэрэгт хадгална.


Найм. Удирдлагын зөвлөлийн гишүүдийн хүлээх үүрэг

8.1. Шуурхай зөвөлгөөнд ээлжийн амралттай, өвчтэй чөлөөтэй, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаас бусад тохиолдолд өөрийн биеэр оролцоно.

8.2. Төвийн даргын зөвшөөрлөөр чөлөө авна.

8.3. Шуурхайгаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг нэхэж шаардуулахгүйгээр хугацаатай, яаралтай өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хангаж ажиллана.

Нийслэлийн Хан-Уул Эруул мэндийн төвийн
даргын 2017 оны 08 сарын 21-ны өдрийн
... дугаар тушаалын хавсралт...



ЭМЧ НАРЫН ШУУРХАЙ ЗӨВӨЛГӨӨНИЙ ХУВААРЬ

№	Шуурхай хийх өдөр	Шуурхай хийх цаг
1	2017.07.25	15 ³⁰ - 16 ⁴⁰
2	2017.08.08	15 ³⁰ - 16 ⁴⁰
3	2017.08.22	15 ³⁰ - 16 ⁴⁰
4	2017.09.05	15 ³⁰ - 16 ⁴⁰
5	2017.09.19	15 ³⁰ - 16 ⁴⁰
6	2017.10.03	15 ³⁰ - 16 ⁴⁰
7	2017.10.17	15 ³⁰ - 16 ⁴⁰
8	2017.10.31	15 ³⁰ - 16 ⁴⁰
9	2017.11.14	15 ³⁰ - 16 ⁴⁰
10	2017.11.28	15 ³⁰ - 16 ⁴⁰
11	2017.12.12	15 ³⁰ - 16 ⁴⁰
12	2017.12.26	15 ³⁰ - 16 ⁴⁰